



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/1/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2024 оны 04 дүгээр сарын 19- ний өдөр</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: <a href="mailto:Altantuyam@audit.gov.mn">Altantuyam@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: <a href="mailto:Doljmaab@audit.gov.mn">Doljmaab@audit.gov.mn</a> Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: <a href="mailto:Narangerelb@audit.gov.mn">Narangerelb@audit.gov.mn</a> Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: <a href="mailto:Bunchinsurenn@audit.gov.mn">Bunchinsurenn@audit.gov.mn</a> Аудитор: Б.Наранцэцэг Утас: 88093788 Цахим хаяг: <a href="mailto:Narantsetsegb@audit.gov.mn">Narantsetsegb@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	10
3.4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	10
3.4.2 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	10
3.4.3 Богино хугацаат хөрөнгө оруулалт .....	13
3.4.4 Авлага .....	13
3.4.5 Урьдчилгаа .....	15
3.4.6 Бараа материал .....	16
3.4.7 Үндсэн хөрөнгө .....	17
3.4.8 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....	19
3.4.9 Өр төлбөр .....	19
3.4.10 Засгийн газрын хувь оролцоо .....	21
3.5.3. Нэмэлт төсөв .....	22
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	22
4.1. Ерөнхий зүйл .....	22
4.2 Материаллаг байдал .....	22
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	23
4.6 санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	24
4.6.1 Шилэн дансны мэдээлэл .....	24
4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	25
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	26
4.7.1 Завсрын аудитын талаар .....	26
4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	26
4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	28
Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	28
5. Аудитын илрүүлэлт .....	32
5.1. Зөвлөмж .....	32
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	34

## Товчилсон үгийн жагсаалт

АОУС,	Аудитын олон улсын стандарт
АДБОУС,	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС,	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС,	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
СХАА,	Санхүүгийн хяналт аудитын алба
СТХС	Санхүү Төрийн сангийн хэлтэс
СХСан	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЦТ	Цахилгаан түгээх
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн тэргүүлэгчдийн хурал
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН



### БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2024.04.19 № 2/113

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант онд Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 241-р тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 15/42 тоот тогтоолоор 3,446.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, мөн орон нутгийн захиргааны байгууллагын төрийн захиргааны

5020422

албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 20%+20% буюу 40%-иар үндсэн цалингаас тооцож сар бүр олгохоор баталсан байна.

Тайланд онд аймгийн татварын орлогоор 20,190.1 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс 23,644.6 сая төгрөг оруулж, төлөвлөгөө 3,454.5 сая төгрөгөөр давж биелсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 2,401.0 сая төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс 2,401.0 сая төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулж, 4 зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайланд аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээллийг тусгана.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 6 үндсэн зорилтын хүрээнд 194 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтэд аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс хяналтыг хэрэгжүүлж 89.1 хувьтай үнэлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх

талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

A handwritten signature in black ink, appearing to be 'B. Mönkhbat', is written over a red rectangular stamp. The stamp contains some illegible text and a central emblem.

Б.МӨНХБАТ

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		39,328,004.7	42,115,489.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	16,694,057.5	15,667,629.2
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	9,536,539.5	9,639,062.2
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	382,472.9	627,134.6
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	4,345,421.3	8,069,233.9
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	8,369,513.5	8,112,429.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		115,467,245.7	124,003,493.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	115,467,245.7	124,003,493.2
39200	Биет хөрөнгө		104,250,534.7	112,778,572.1
39300	Биет бус хөрөнгө	13	11,216,711.0	11,224,921.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		154,795,250.4	166,118,982.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		13,037,286.3	10,253,132.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	5,968,578.8	4,306,401.4
41300	Өглөг	17а, 17б	5,367,118.6	4,139,357.6
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	601,460.2	167,043.8
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		7,068,707.5	5,946,730.8
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	7,068,707.5	5,946,730.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		141,757,964.1	155,865,849.9
51	Засгийн газрын хувь оролцоо		141,757,964.1	155,865,849.9
51100	Засгийн газрын оруулсан капитал		52,363,723.6	53,741,318.7
51200	Хуримтлагдсан үр дүн		71,921,315.2	84,975,984.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		17,472,925.3	17,148,547.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		154,795,250.4	166,118,982.2

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		170,335,999.8	161,539,916.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО		21,237,011.8	24,092,945.2
110	Орлогын албан татвар		11,809,360.5	14,203,722.0
1100	Хувь хүний орлогын албан татвар		12,258,857.8	14,321,865.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(593,169.7)	(795,573.8)
1103	ААН-ын орлогын албан татвар		143,672.5	677,430.2
113	Хөрөнгийн албан татвар		2,135,861.5	2,701,676.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		7,291,789.8	7,187,547.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	71,385,319.2	90,779,520.0
120	Нийтлэг татварын бус орлого		43,521,751.6	50,211,311.4
121	Хөрөнгийн орлого		72,282.9	0.0
122	Тусламжийн орлого		0.0	2,180,000.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		27,791,284.6	38,388,208.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		77,713,668.8	46,667,451.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	147,022,473.6	147,159,931.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		147,022,473.6	147,159,931.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		80,705,339.5	131,554,252.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		9,958,153.1	15,215,656.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,245,316.3	1,872,524.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,258,363.5	1,639,396.9
2104	Хангамж, бараа материалын зардал		2,540,184.8	6,918,395.0
2105	Нормативт зардал		212,856.0	123,978.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		324,349.6	482,196.0
2107	Томилот, зочны зардал		161,413.5	357,571.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		39,127,209.1	74,395,077.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		25,877,493.5	30,549,455.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		66,317,134.1	15,605,678.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		23,313,526.2	14,379,985.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		155,495,470.4	2,775,919.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		(132,181,944.3)	11,604,065.5

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	162,331,257.6	135,838,788.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	21,685,339.4	23,644,617.7
110	Орлогын албан татвар	11,933,694.4	13,755,394.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	11,934,864.1	14,321,865.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(593,169.7)	(795,573.8)
1103	ААН-ын орлогын албан татвар	592,000.0	229,102.7
113	Хөрөнгийн албан татвар	2,136,903.1	2,701,676.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	7,614,741.9	7,187,547.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,606,452.1	2,108,880.8
1181	Газрын төлбөр	696,170.4	1,055,215.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	5,078,545.1	4,012,182.8
1183	Бусад татвар	233,574.3	11,267.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,437,986.5	65,650,676.3
120	Нийтлэг татварын бус орлого	22,574,418.9	25,082,467.7
121	Хөрөнгийн орлого	72,282.9	0.0
122	Тусламжийн орлого	0.0	2,180,000.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	27,791,284.6	38,388,208.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	90,207,931.8	46,543,494.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	125,112,677.0	70,334,768.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,112,677.0	70,334,768.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,492,493.5	67,948,199.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,840,982.9	15,492,197.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,457,717.5	1,908,851.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,000,224.6	14,062,164.1
2104	Хангамж, бараа материалын зардал	1,977,859.2	2,362,183.3
2105	Нормативт зардал	227,834.0	128,239.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	497,726.8	1,129,480.4
2107	Томилолт, зочны зардал	163,582.5	361,474.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,235,175.9	13,644,441.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,091,390.1	18,859,167.0
212	ТАТААС	26,504.2	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,593,679.3	2,386,568.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	37,218,580.6	65,504,020.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	37,778,064.7	65,867,333.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,778,064.7	65,867,333.6
2200	Дотоод эх үүсвэрээр	37,778,064.7	65,867,333.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(37,778,064.7)	(65,867,333.6)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(548,840.9)	(663,114.6)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	548,840.9	663,114.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(1,108,325.1)	(1,026,428.3)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,802,382.5	16,694,057.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,694,057.5	15,667,629.2

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,797,690.7	275,797,690.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,964,117.6)	(2,964,117.6)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	272,833,573.2	272,833,573.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(29,294.3)	(29,294.3)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,135,629.5	1,135,629.5
9	Тайлант үеийн үр дүн	(132,181,944.3)	(132,181,944.3)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	141,757,964.1	141,757,964.1
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	141,757,964.1	141,757,964.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,925,302.0	2,925,302.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	144,683,266.0	144,683,266.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(366,806.6)	(366,806.6)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(54,675.1)	(54,675.1)
19	Тайлант үеийн үр дүн	11,604,065.5	11,604,065.5
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	155,865,849.9	155,865,849.9

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

( мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>77,916,328.8</b>	<b>69,931,027.9</b>	<b>7,985,300.9</b>	<b>89.8</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>50,390,226.8</b>	<b>46,804,406.0</b>	<b>3,585,820.8</b>	<b>92.9</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>48,146,100.2</b>	<b>44,803,422.4</b>	<b>3,342,677.8</b>	<b>93.1</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,614,405.7	15,267,032.8	347,372.9	97.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,984,335.3	1,874,380.8	109,954.5	94.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,497,295.9	14,052,254.0	445,041.9	96.9
2104	Хангамж, бараа материалын зардал	2,459,748.5	2,362,524.1	97,224.4	96.0
2105	Нормативт зардал	86,737.8	85,192.1	1,545.7	98.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,594,778.6	1,506,853.7	87,924.9	94.5
2107	Томиллот, зочны зардал	382,544.2	361,474.7	21,069.5	94.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,490,679.3	2,203,919.3	286,760.0	88.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,035,574.9	7,089,791.0	1,945,783.9	78.5
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,244,126.6</b>	<b>2,000,983.5</b>	<b>243,143.1</b>	<b>89.2</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,543,855.0	1,439,157.7	104,697.3	93.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,271.6	561,825.8	138,445.8	80.2
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>26,775,417.6</b>	<b>22,463,507.3</b>	<b>4,311,910.3</b>	<b>83.9</b>
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>750,684.4</b>	<b>663,114.6</b>	<b>87,569.8</b>	<b>88.3</b>
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>77,916,328.8</b>	<b>70,138,706.1</b>	<b>7,777,622.7</b>	<b>90.0</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>15,405,295.1</b>	<b>0.0</b>	<b>15,405,295.1</b>	<b>0.0</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>50,739,417.6</b>	<b>65,180,338.2</b>	<b>(14,440,920.6)</b>	<b>128.5</b>
33	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.0</b>	<b>2,778,368.0</b>	<b>(2,778,368.0)</b>	
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>7,791,547.4</b>	<b>2,180,000.0</b>	<b>5,611,547.4</b>	<b>28.0</b>
36	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>3,980,068.7</b>	<b>2,180,000.0</b>	<b>1,800,068.7</b>	<b>54.8</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□		4,147,879.1		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□		4,355,557.2		
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1,751</b>	<b>1,661</b>	<b>90</b>	<b>94.9</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>49</b>	<b>49</b>	<b>0</b>	<b>100.0</b>
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>851</b>	<b>806</b>	<b>45</b>	<b>94.7</b>
620001	Удирдах ажилтан	219	219	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	461	463	(2)	100.4
620003	Үйлчлэх ажилтан	110	112	(2)	101.8
620004	Гэрээт ажилтан	61	51	10	83.6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

( мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,612,006.1</b>	<b>2,640,029.4</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,601,919.6</b>	<b>2,639,399.5</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,263,786.5</b>	<b>2,099,764.3</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	1,468.3	600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,997.9	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,252,320.3	2,086,964.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		12,200.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>338,133.1</b>	<b>539,635.2</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	120,000.0	40,000.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	218,133.1	499,635.2
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,086.5</b>	<b>629.9</b>
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,612,006.1</b>	<b>2,640,029.4</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,612,006.1	2,640,029.4
III	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		<b>0.0</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймаг нь 2023 онд “Авилаггүй шударга төр, Архигүй айл өрх, Ажил орлоготой иргэн” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хууль
- УИХ-аас 2022 оны 04 сарын 29 өдөр “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийг баталж мөрдүүлсэн.
- Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Монгол улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох” тухай 241 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох” тухай 240 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2023 оны “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох” тухай 241 дүгээр тогтоол
- Бусад хууль, тогтоол, журам заавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн төсвийн ТЕЗ-ийн дотоод хяналтыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хариуцан хэрэгжүүлж, албаны дарга, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор 2, дотоод аудитор 3, гэрээт ажилтан 2, хүний нөөц, архив, бичиг хэрэг, нягтлан бодогч, дотоод ажилтан 1 нийт 9 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа, аймгийн Засаг даргын салбарын сайдтай байгуулсан гэрээний үндсэн дээр бусад хэлтэс, агентлагийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2023 оны байдлаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасны дагуу төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт 64, дотоод аудит 26, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 3, аймгийн Засаг даргын захирамжаар 2, нийт 95 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн байна.

Дээрх хяналт шалгалтаар 510.0 сая төгрөгийн 48 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн, улсын ахлах байцаагчийн 147.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосны 71.2 сая төгрөг нь

орон нутгийн төсөвт, 76.7 сая төгрөгийг тухайн байгууллагын төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэж, 283.8 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж ажилласан байна.

Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хороо нь аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, аймгийн Цагдаагийн газрын дарга, Мэргэжлийн төлөөлөл-2, Иргэдийн төлөөлөл-2, нарийн бичгийн дарга гэсэн бүтэц бүрэлдэхүүнтэй бөгөөд 2023 онд 4 удаа хуралдаж 86 байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын тайланг хэлэлцэж, баталгаажуулж, 56 албан тушаалтанд сахилгын арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн саналыг хүргүүлж биелэлтийг тооцон ажилласан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

#### 3.4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 166,119.0 сая төгрөг болж өмнөх оноос 7.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр өмч (сая төгрөг)

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Дүнд эзлэх хувь	
				Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Эргэлтийн хөрөнгийн дүн	39,328.0	42,115.5	2,787.5	25.4	25.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	115,467.2	124,003.5	8,536.2	74.6	74.6
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>154,795.3</b>	<b>166,119.0</b>	<b>11,323.7</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Нийт өр төлбөр	13,037.3	10,253.7	(2,783.6)	8.4	6.2
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	141,758.0	155,865.3	14,107.3	91.6	93.8
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>154,795.3</b>	<b>166,119.0</b>	<b>11,323.7</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.4.2 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 16,694.1 сая, эцсийн үлдэгдэл 15,665.5 сая төгрөг болж, өмнөх оноос 1,026.4 сая төгрөгөөр буюу 6.1 хувиар буурсан байна. Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 14,640.8 сая буюу 93.4 хувь нь касс болон төрийн сангийн харилцах дансанд, 1,026.8 сая буюу 6.6 хувь нь арилжааны банканд байршиж байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл (сая төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банканд байгаа бэлэн мөнгө		Өсөлт (+), Бууралт (-)
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс	
<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>	<b>2.4</b>	<b>2.1</b>	<b>2.1</b>	-	-	<b>(0.3)</b>
Төгрөг/ ЖМС	2.4	2.1	2.1			(0.3)
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>16,691.7</b>	<b>15,665.5</b>	-	<b>1,026.8</b>	<b>14,638.7</b>	<b>(1,026.2)</b>
Төгрөг	16,691.7	15,665.5		1,026.8	14,638.7	(1,026.2)
<b>Нийт мөнгөн хөрөнгийн дүн</b>	<b>16,694.1</b>	<b>15,667.6</b>	<b>2.1</b>	<b>1,026.8</b>	<b>14,638.7</b>	<b>(1,026.4)</b>

<b>Үүнээс байгууллагын төрлөөр:</b>						-
Төрийн сан	7,121.2	6,535.3	-	6,535.3	(586.0)	
Төсөвт байгууллагууд /ОНХС, ХХС, Замын сан/	4,147.9	4,355.5	0.9	4,354.6	207.7	
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	704.6	1,028.0	2.1	1,025.9	-	323.5
Төсөл, сангууд	4,720.4	3,748.8	-	3,748.8	(971.6)	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө оны эхэнд 7,121.2 сая төгрөг байснаас оны эцэст 6,535.3 сая төгрөг болж өмнөх оноос 586.0 сая төгрөгөөр буурсан байна.

Энэ нь орон нутгийн давсан орлого 4,007.6 сая, төсөвт байгууллагуудын харилцах дансны зарцуулагдаагүй үлдэгдлийг Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн 1,888.7 сая, урьд оны харилцах дансны 639.0 сая төгрөгийг зарцуулаагүйгээс нийт 6,535.3 сая төгрөг байна.

Хүснэгт 3. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл (сая төгрөг)

Төрийн сангийн ерөнхий орлогын данс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс			Өсөлт (+), Бууралт (-)
			Орон нутгийн давсан орлого	Буцаан төвлөрүүлэлт	Урьд оны зарцуулаагүй үлдэгдэл	
Галуут	273.5	253.0	3.9	59.4	189.7	(20.5)
Баян-овоо	214.9	56.4	-	13.0	43.5	(158.5)
Эрдэнэцогт	380.0	302.0	253.1	48.9	-	(78.0)
Бууцагаан	197.0	422.2	338.1	84.1	-	225.2
Жинст	47.0	50.8	25.9	23.4	1.6	3.8
Богд	147.4	267.4	238.1	29.3	-	120.0
Баянлиг	68.7	37.8	14.4	21.0	2.4	(30.9)
Баянговь	72.2	189.9	133.5	56.4	-	117.7
Гурванбулаг	424.6	341.1	198.3	142.8	-	(83.5)
Жаргалант	210.3	278.6	246.0	32.6	-	68.3
Заг	682.7	480.6	118.8	218.2	143.7	(202.1)
Баацагаан	236.9	161.7	1.5	137.2	23.0	(75.2)
Бөмбөгөр	246.3	93.1	-	41.0	52.1	(153.2)
Өлзийт	905.4	520.4	292.8	227.6	0.0	(385.0)
Хүрээмарал	130.2	167.1	85.1	81.9	-	36.9
Баянбулаг	180.0	458.2	415.7	42.5	-	278.2
Шинэжинст	109.3	468.9	301.9	57.8	109.3	359.7
Баянцагаан	447.7	383.0	199.1	183.9	-	(64.7)
Баян-өндөр	136.4	263.2	173.9	89.3	-	126.8
Баянхонгор сум	1,200.6	1,145.9	967.5	178.4	-	(54.7)
<b>Сумдын дүн</b>	<b>6,311.1</b>	<b>6,341.5</b>	<b>4,007.6</b>	<b>1,768.6</b>	<b>565.2</b>	<b>30.4</b>
Баянхонгор аймаг	810.1	193.8	-	120.0	73.7	(616.3)
<b>Нийт дүн</b>	<b>7,121.2</b>	<b>6,535.3</b>	<b>4,007.6</b>	<b>1,888.7</b>	<b>639.0</b>	<b>(586.0)</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст төсвийн ерөнхий орлогын данс 6,535.3 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 6,341.5 сая төгрөг нь 20 сумын орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл бөгөөд оны эцэст аймгийн төвийн төсөвт байгууллагууд зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлснээс 120.0 сая, урьд оны зарцуулаагүй үлдэгдэл 73.7 сая, нийт 193.8 сая төгрөг аймгийн орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээр байна.

### Төсөвт байгууллага, сангийн мөнгөн хөрөнгө:

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,147.9 сая, эцсийн үлдэгдэл 4,355.6 сая төгрөг болж, өмнөх оноос 207.7 сая төгрөгөөр өссөн ба хоршоо хөгжүүлэх сангийн 1,384.3 сая, орон нутгийн хөгжлийн сангийн 2,931.3 сая, замын сангийн 39.0 сая, өрхийн эмнэлгүүдийн арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэл 0.9 сая төгрөг байна.

Хүснэгт 4. Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл (сая төгрөг)

Дд	Сумын нэр	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
		ХХСан	ОНХСан	Замын сан	Өрхийн эмнэлгүүд
1	Галуут	28.7	171.1	-	-
2	Баян-Овоо	90.5	75.2	-	-
3	Эрдэнэцогт	41.3	48.3	-	-
4	Бууцагаан	25.3	59.9	-	-
5	Жинст	58.3	15.0	-	-
6	Богд	100.5	48.9	-	-
7	Баянлиг	113.2	420.1	-	-
8	Баянговь	46.2	94.2	-	-
9	Гурванбулаг	131.4	161.4	-	-
10	Жаргалант	67.3	148.6	-	-
11	Заг	65.2	74.9	-	-
12	Баацагаан	66.5	134.1	-	-
13	Бөмбөгөр	57.2	194.1	-	-
14	Өлзийт	124.2	183.4	-	-
15	Хүрээмарал	4.0	74.3	-	-
16	Баянбулаг	63.1	153.4	-	-
17	Шинэжинст	54.0	101.2	-	-
18	Баянцагаан	64.4	114.9	-	-
19	Баян-Өндөр	21.3	595.8	-	-
20	Баянхонгор сум	161.7	59.4	-	-
21	Аймгийн ОНХС	-	3.2	-	-
22	Аймаг	-	-	39.0	0.9
<b>Нийт дүн</b>		<b>1,384.3</b>	<b>2,931.3</b>	<b>39.0</b>	<b>0.9</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 238.4 сая төгрөгөөс өссөн нь сангийн зээлийн эргэн төлөлтийн орлого нэмэгдсэнээс шалтгаалсан бол Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 35.4 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 5. Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл (сая төгрөг)

Сумд	Хоршоо хөгжүүлэх сан			Орон нутгийн хөгжлийн сан		
	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
Галуут	39.9	28.7	(11.2)	182.2	171.1	(11.1)
Баян-Овоо	13.9	90.5	76.6	98.0	75.2	(22.8)
Эрдэнэцогт	104.9	41.3	(63.6)	77.0	48.3	(28.7)
Бууцагаан	47.9	25.3	(22.6)	76.9	59.9	(17.0)
Жинст	0.1	58.3	58.2	26.8	15.0	(11.8)
Богд	26.2	100.5	74.3	15.6	48.9	33.3
Баянлиг	210.6	113.2	(97.4)	269.2	420.1	150.9
Баянговь	6.7	46.2	39.5	36.8	94.2	57.4
Гурванбулаг	102.7	131.4	28.7	91.9	161.4	69.5
Жаргалант	109.1	67.3	(41.8)	64.2	148.6	84.4
Заг	27.2	65.2	38.0	74.5	74.9	0.4
Баацагаан	6.8	66.5	59.7	66.0	134.1	68.1
Бөмбөгөр	20.1	57.2	37.1	308.9	194.1	(114.8)
Өлзийт	40.4	124.2	83.8	16.0	183.4	167.4
Хүрээмарал	116.4	4.0	(112.4)	107.3	74.3	(33.0)
Баянбулаг	29.9	63.1	33.2	71.9	153.4	81.5
Шинэжинст	38.2	54.0	15.8	486.2	101.2	(385.0)
Баянцагаан	59.8	64.4	4.6	282.2	114.9	(167.3)
Баян-Өндөр	43.7	21.3	(22.4)	487.1	595.8	108.7
Баянхонгор сум	101.4	161.7	60.3	104.4	59.4	(45.0)
Аймгийн ОНХС	-	-	-	23.6	3.2	(20.4)
<b>Дүн</b>	<b>1,145.9</b>	<b>1,384.3</b>	<b>238.4</b>	<b>2,966.7</b>	<b>2,931.3</b>	<b>(35.4)</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Төсөл сангийн мөнгөн хөрөнгө:**

Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 971.6 сая төгрөгөөр буурч, 3748.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 2,542.2 сая төгрөг нь улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнээс тооцсон барьцаа, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн Барилгын тухай хуульд заасан баталгаат хугацааны баталгаа болон улсын төсвөөс хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний дутуу олгосон санхүүжилт байгаа бол 693.4 сая төгрөг нь улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнээс суутган тооцсон хяналтын зардал болон бусад зардлын зарцуулаагүй үлдэгдэл, орон нутгийн нөөц сангийн дансны

үлдэгдэлд байгаа 513.2 сая төгрөг нь төсвийн байгууллагуудын нэмэлт дансны буцаан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэл байна.

**Хүснэгт 6. Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл (сая төгрөг)**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутгийн нөөц сан	225.0	513.2	288.2	13.7
Техник хяналт данс	379.7	693.4	313.7	18.5
Барьцаа хөрөнгийн данс	4,115.7	2,542.2	(1,573.5)	67.8
Нийт дүн	4,720.4	3,748.8	(971.6)	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дэх “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасны дагуу ТШЗ-ийн 34 байгууллага нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдэл 513.2 сая төгрөгийг оны эцэст орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

**Арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгө:**

Арилжааны банканд байршиж байгаа мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 703.4 сая, эцсийн үлдэгдэл 1,026.8 сая төгрөг болж, 323.4 сая төгрөгөөр өссөн бөгөөд үлдэгдлийн 99.9 хувийг ТӨҮГ болон ОНӨААН-ийн үлдэгдэл, 0.1 хувийг өрхийн эмнэлгүүдийн харилцах дансны үлдэгдэл эзэлж байна.

**Хүснэгт 7. Арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл (сая төгрөг)**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	1.2	0.9	(0.3)	0.1
ТӨҮГ болон ОНӨҮГ	702.2	1,025.9	323.7	99.9
<b>Дүн</b>	<b>703.4</b>	<b>1,026.8</b>	<b>323.4</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТӨҮГ болон ОНӨҮГ-ийн харилцах дансны үлдэгдэл 1,025.9 сая төгрөг байгаагаас “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн харилцах дансны үлдэгдэл 491.5 сая, “Чандмань Баянхонгор” ХК-ийн үлдэгдэл 458.9 сая, “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн үлдэгдэл 73.8 сая төгрөг байгаа нь голлох нөлөөг үзүүлж байна.

Төсөвт байгууллагын арилжааны банкны үлдэгдэл 0.9 сая төгрөг байгаа нь аймгийн төвийн 4 өрхийн эмнэлгийн харилцах дансны үлдэгдэл байна.

Аудитын явцад Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкуудад албан бичиг хүргүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын арилжааны банк дахь харилцах дансны мэдээллийг авахад төсвөөс гадуур данс нээгээгүй байна.

**3.4.3 Богино хугацаат хөрөнгө оруулалт**

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат хөрөнгө оруулалт байхгүй.

**3.4.4 Авлага**

Авлага дансны эхний үлдэгдэл 9,536.5 сая, эцсийн үлдэгдэл 9,639.1 сая төгрөг болж, 102.6 сая төгрөгөөр өссөн бөгөөд нийт авлагын 36.5 хувь буюу 3,514.1 сая төгрөгийг хувь хүмүүс болон байгууллагаас авах авлага, 59.6 хувь буюу 5,746.8 сая төгрөгийг сумдын хоршоо хөгжүүлэх сан, “Баянхонгор-Үйлдвэржилт хөгжлийн корпорац”-ийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр олгосон зээлийн авлага, харин 3.1 хувь буюу 297.8 сая төгрөг нь Хүрээмарал сумын ЗДТГ-н нэмэлт санхүүжилтийн авлага 90.0 сая, Наранмандал, Оточ мандал, Оточ номгон, Энхбүрд өрхийн эмнэлгүүдийн татаас санхүүжилтийн авлага 207.8 сая төгрөг байна.

**Хүснэгт 8. Авлагын үлдэгдэл (сая төгрөг)**

Ангилал	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), бууралт (-)	Хувь
Ажилчидтай холбогдсон авлага	13.6	14.10	0.50	0.1%
Төлбөрт үйлчилгээний авлага	16.2	19.10	2.9	0.2%
Татаас, санхүүжилтийн авлага	0	297.80	297.8	3.1%

Дансны авлага /ТӨҮГ/	10.6	32.50	21.9	0.3%
Зээлийн хүүгийн авлага		14.70	14.7	0.2%
Бусад авлага	3,376.70	3,514.10	137.4	36.5%
Зээлийн авлага	6,119.40	5,746.80	(372.6)	59.6%
<b>Дүн</b>	<b>9,536.50</b>	<b>9,639.10</b>	<b>102.60</b>	<b>100%</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр:</b>			<b>0</b>	<b>-</b>
Төсөвт байгууллага	6,036.80	6,376.00	<b>339.2</b>	66.1%
Төсөл/сан	0		<b>0</b>	0.0%
ТӨҮГ болон ОНӨҮГ	3,499.70	3,263.10	<b>(236.6)</b>	33.9%
<b>Нийт дүн</b>	<b>9,536.50</b>	<b>9,639.10</b>	<b>102.6</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь авлагын дансны бүртгэлийг тооцоо нийлсэн акт, насжилтаар ангилж харуулбал нийт авлагын 86.2 хувь буюу 8,306.2 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, нийт авлагын 49.4 хувь буюу 4,757.8 сая төгрөгийн үлдэгдэл нь 4-өөс дээш жилийн насжилттай, 23.8 хувь буюу 2,292.7 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн гэсэн ангиллаар нэгтгэгдсэн байна.

**Хүснэгт 9. Авлагын үлдэгдэл насжилтаар (сая төгрөг)**

Ангилал	Ажилчидтай холбогдсон авлага	Төлбөрт үйлчилгээний авлага	Дансны авлага /ТӨҮГ/	Байгууллагаас авах авлага	Хувь хүмүүсээс авах авлага	Зээлийн авлага	Татаас санхүүжилт-ийн авлага	Нийт	Эзлэх хувь
Тооцоо нийлсэн				151.5	133.9	957.5	90.0	1,332.9	13.8
Тооцоо нийлсэн акт байхгүй	14.1	19.1	32.5	2,764.6	464.1	4,804.0	207.8	8,306.2	86.2
<b>Дүн</b>									<b>100.0</b>
Үүнээс авлагын насжилтаар:									
Эц.Үлд 0-1 жил	3.6	9.9	-	741.8	66.6	448.5	297.8	1,568.2	16.3
Эц.Үлд 1-2 жил	1.8	-	32.4	695.6	12.0	1,184.1	-	1,925.9	20.0
Эц.Үлд 2-3 жил	-	-	-	64.8	266.6	553.6	-	885.0	9.2
Эц.Үлд 3-4 жил	-	-	0.1	0.2	202.2	299.7	-	502.2	5.2
Эц.Үлд 4-5 жил	-	9.2	-	126.1	2.0	2,637.8	-	2,775.1	28.8
Эц.Үлд 5-аас дээш жил	8.7	-	-	1,287.6	-	637.8	-	1,982.7	20.6
<b>Нийт дүн</b>	<b>14.1</b>	<b>19.1</b>	<b>32.5</b>	<b>2,916.1</b>	<b>598.0</b>	<b>5,761.5</b>	<b>297.8</b>	<b>9,639.1</b>	<b>100.0</b>
Үүнээс хугацаа хэтэрсэн ангиллаар бүртгэсэн:									
0-1 жил	-	-	-	58.7	-	149.5	-	208.2	2.2
1-2 жил	-	-	-	-	-	11.4	-	11.4	0.1
2-3 жил	-	9.2	-	-	-	79.6	-	88.8	0.9
3-4 жил	-	-	-	-	-	17.9	-	17.9	0.2
4-5 жил	-	-	-	-	129.0	1,808.2	-	1,937.2	20.1
5-аас дээш жил	-	-	-	3.1	4.9	24.6	-	26.6	0.3
<b>Нийт дүн</b>	<b>-</b>	<b>9.2</b>	<b>-</b>	<b>61.8</b>	<b>133.9</b>	<b>2,087.8</b>	<b>-</b>	<b>2,292.7</b>	<b>23.8</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Аудитын илрүүлэлт:**

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд э тайлангийн тодруулга тайланд авлагын насжилт болон авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажсан эсэхийг үнэн зөв бүртгээгүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хангалттай хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 5,746.8 сая төгрөгийн зээлийн авлага байгаа бөгөөд үүний 31.1 хувь нь буюу 1,785.8 сая төгрөг нь “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгож буй хөнгөлөлттэй зээлийн авлага, 68.1 хувь буюу 3,913.6 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 0.8 хувь буюу 47.4 сая төгрөгийн авлага нь Шинэжинст сумын ЗДТГ, Баян-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангийн малчдад зээлээр олгосон өвс тэжээлийн авлагын үлдэгдэл байна.

Хүснэгт 10. Зээлийн авлага (сая төгрөг)

Байгууллагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Сум хөгжүүлэх сан	4,094.5	3,913.6	(180.9)
“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК	1,983.6	1,785.8	(197.8)
Бусад төсөвт байгууллага	41.3	47.4	6.1
<b>Дүн</b>	<b>6,119.4</b>	<b>5,746.8</b>	<b>(372.6)</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн авлага 2023 оны эхний үлдэгдэл 4,094.5 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 3,913.6 сая төгрөг болж 180.9 сая төгрөгөөр буурсан байна.

Энэ нь тайлант онд нийт 996.5 сая төгрөгийн зээл олгож, 1,177.4 сая төгрөгийн зээлийн төлбөрийг төлүүлсэнтэй холбоотой ба энэ хэмжээгээр СХС-ийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,384.3 сая төгрөг болж өмнөх оноос 238.4 сая төгрөгөөр өссөн байна.

“Баянхонгор Үйлдвэржилт Корпорац” ХХК нь тайлант онд 582.0 сая төгрөгийн жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийг олгож, 197.8 сая төгрөгийн зээлийн төлбөр төлөгдсөн байна.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл Баянхонгор сум хамгийн өндөр буюу 912.4 сая, Гурванбулаг сум хамгийн бага буюу 72.5 сая төгрөгийн авлагатай байна.

Хүснэгт 11. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага сумдаар (сая төгрөг)

№	Сумын нэр	Хувь хүмүүст олгосон зээлийн авлага		№	Сумын нэр	Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	
		Өмнөх он	Тайлант он			Өмнөх он	Тайлант он
1	Баянбулаг	185.6	157.7	11	Баян-Өндөр	157.5	178.0
2	Баянговь	204.5	167.7	12	Галуут	231.2	248.9
3	Богд	184.3	112.4	13	Гурванбулаг	101.3	72.5
4	Баянлиг	45.3	144.7	14	Жаргалант	149.7	181.7
5	Баян-Овоо	158.1	81.4	15	Жинст	193.4	134.6
6	Бөмбөгөр	166.7	130.3	16	Заг	166.8	133.7
7	Бууцагаан	190.1	215.5	17	Хүрээмарал	87.9	209.8
8	Баянхонгор	960.8	912.4	18	Шинэжинст	168.4	156.0
9	Баацагаан	249.1	191.8	19	Эрдэнэцогт	80.2	146.5
10	Баянцагаан	204.8	203.2	20	Өлзийт	208.7	132.7
<b>НИЙТ ДҮН</b>						<b>4,094.5</b>	<b>3,913.6</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.5 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 382.5 сая, эцсийн үлдэгдэл 627.1 сая төгрөг болж, өмнөх оноос 244.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 12. Урьдчилгаа дансны үлдэгдэл (сая төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Хувь
Урьдчилж гарсан зардал	255.5	220.8	(34.7)	35.2
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	126.7	406.0	279.3	64.7
Цалингийн урьдчилгаа	0.3	0.3	-	0.1
<b>Дүн</b>	<b>382.5</b>	<b>627.1</b>	<b>244.6</b>	<b>100.0</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	0.3	0.3	-	0.1
ТӨҮГ болон ОНӨҮГ	382.2	626.8	244.6	99.9
<b>Дүн</b>	<b>382.5</b>	<b>627.1</b>	<b>244.6</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд бүртгэлтэй 627.1 сая төгрөгийн үлдэгдлээс 406.0 сая төгрөг нь “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн “Шинэ суурьшлын бүсийн цахилгааны дэд өртөөний шугам сүлжээний ажил”-ын, 181.0 сая төгрөг нь “Чандмань- Баянхонгор” ХК-ийн

лабораторийн барилгын, 39.8 сая төгрөг нь “Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ын 2022 оны хөрөнгө бэлтгэхтэй холбоотой урьдчилж гарсан зардал байна.

Харин цалингийн урьдчилгааны 0.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэл нь Баянговь сумын ЗДТГ-ын цалингийн урьдчилгааны өмнөх оны авлага байна.

### 3.4.6 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 4,345.4 сая төгрөг байсан ба оны эцэст үлдэгдэл 8,069.2 сая төгрөг болж, 85.7 хувиар буюу 3,723.8 сая төгрөгөөр өссөн, нөөцийн барааны эхний үлдэгдэл 8,369.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,112.4 сая төгрөг болж 257.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 13. Бараа материалын үлдэгдэл (сая төгрөг)

БАРАА МАТЕРИАЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
Тусгай зориулалтын материал	317.0	706.9	389.9	4.4
Эм боох материал	5.3	54.5	49.2	0.3
Дуусаагүй үйлдвэрлэл	540.8	1,203.9	663.1	7.4
Бэлэн бүтээгдэхүүн	99.8	93.3	(6.5)	0.6
Бичиг хэргийн материал	87.6	133.7	46.1	0.8
Аж ахуйн материал	1,317.6	2,888.4	1,570.8	17.8
Сэлбэг хэрэгсэл	70.6	109.4	38.8	0.7
Түлш, шатах тослох материал	3.7	7.1	3.4	0.0
Барилгын засварын материал	13.7	24.3	10.6	0.2
Хүнсний материал	1.4	3.2	1.8	0.0
Бусад хангамжийн материал	1,731.5	2,447.9	716.4	15.1
Биологийн хөрөнгө	-	15.8	15.8	0.1
Мал амьтад	156.5	380.8	224.3	2.4
<b>Бараа материалын дүн</b>	<b>4,345.4</b>	<b>8,069.2</b>	<b>3,723.8</b>	<b>49.9</b>
Нөөцийн бараа	8,369.5	8,112.4	(257.1)	50.1
<b>НИЙТ ДҮН</b>	<b>12,714.9</b>	<b>16,181.7</b>	<b>3,466.7</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст төсөвт байгууллагуудын бараа материалын үлдэгдэл 3,723.8 сая төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 389.9 сая, дуусаагүй үйлдвэрлэл 663.1 сая, аж ахуйн материал 1,570.8 сая, бусад хангамжийн материал 716.4 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Харин нөөцийн бараа дансанд бүртгэлтэй 8,112.4 сая төгрөгийн 252.1 сая төгрөг нь Байгаль орчин, аялал жуулчлалын газрын “Тэрбум мод” хөтөлбөртэй холбоотойгоор Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсэд байгуулсан хашаажуулалт, ойн зурвас, усалгааны тоног төхөөрөмж, 5,700.3 сая төгрөг нь аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн дуусаагүй ажил, 743.2 сая төгрөг нь аймгийн ангилагдаагүй зардлаар санхүүжсэн дуусаагүй ажил, 1,123.3 сая төгрөг нь Баянхонгор, Богд, Бууцагаан, Баянцагаан, Хүрээмарал, Эрдэнэцогт сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн дуусаагүй ажлууд байна.

### Аудитын илрүүлэлт:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 152 дугаар тогтоолоор “Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ыг үүсгэн байгуулсан бөгөөд тайлант онд тус байгууллагын дансаар 1.0 сая төгрөгийн орлого орж, 1.0 сая төгрөгийн зарлага гарч, бараа материалын дансанд 132.9 сая төгрөгийн хөдлөл өөрчлөлт орсон байхад Төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайланг гаргаж ирүүлээгүй байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 88.8 хувийг төсөвт байгууллага, 11.2 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал эзэлж байна.

Хүснэгт 14. Бараа материалын хөдлөл өөрчлөлт (сая төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эхний үлдэгдэл	15,117.7	12,714.9	(2,402.8)
<b>Нэмэгдсэн</b>	<b>9,798.9</b>	<b>18,712.3</b>	<b>8,913.4</b>
Худалдан авсан	8,518.6	15,816.5	7,298.0

Хандиваар	368.6	15.7	(352.9)
Шилжүүлэн авсан	378.8	1838.1	1,459.3
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	-	118.1	118.1
Бусад	532.9	923.8	390.9
<b>Хасагдсан</b>	<b>12,201.7</b>	<b>15,245.6</b>	<b>3,043.9</b>
Худалдсан, зарцуулсан	4,009.6	7,080.7	3,071.1
Шилжүүлсэн	233.3	7,879.9	7,646.5
Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	7,774.1	0	(7,646.5)
Бусад	184.6	285.0	100.4
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>12,714.9</b>	<b>16,181.7</b>	<b>3,466.7</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			-
Төсөвт байгууллага	12,091.2	14,367.9	2,276.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	623.7	1,813.7	1,190.0
<b>Дүн</b>	<b>12,714.9</b>	<b>16,181.7</b>	<b>3,466.7</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 15,816.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар 15.7 сая, балансаас баланст 1,838.1 сая төгрөгийн материал шилжүүлэн авч, бүтцийн өөрчлөлтөөр 118.1 сая, бусад хэлбэрээр 923.8 сая нийт 18,712.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 7,080.7 сая төгрөгийн хөрөнгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 7,879.9 сая төгрөгийн бараа материалыг балансаас баланст шилжүүлж, 285.0 сая төгрөгийн бараа материалыг акталж нийт бараа материал 15,245.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

1. Тайлант хугацааны үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал нь тодруулгаас 541.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Мөн Богд сумын ЗДТГ-ын үнэ төлбөргүй хүлээн авсан 334.3 сая, Баянцагаан сумын ЗДТГ-ын үнэ төлбөргүй хүлээн авсан 973.6 сая, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ны 678.6 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг бараа материал дансанд тус тус бүртгэснийг аудитыг явцад залруулав.
2. Тайлант онд Галуут, Баян-Өндөр, Гурванбулаг, Жаргалант сумдын ЗДТГ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 25.1 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар авснаар бүртгэсэн, Өлзийт сумын ЗДТГ-ын бараа материалын дансанд бүртгэлтэй 79.2 сая төгрөгийн ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон өвс тэжээлийг, Өлзийт сумын ИТХ-ын үнэ төлбөргүй хүлээн авч, зарцуулсан шатахууныг Э-тайланд бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлснээр бүртгэснийг аудитын явцад залруулсан.

#### 3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 168,011.0 сая, эцсийн үлдэгдэл 181,232.2 сая төгрөг болж 13,221.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 4 өрхийн эмнэлгийн 2,198.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэсэн, Ингэн эрдэнэ ОНӨААТҮГ-ын 212.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж шинээр бүртгэсэн, Баянхонгор Тохижилт үйлчилгээний газарт уул уурхайн хандив болон улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 5,430.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн, аймгийн Орон нутгийн өмчийн газарт “Чандмань Баянхонгор”ХК-аас шилжүүлэн авсан 2,653.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн нь голлох нөлөө үзүүлжээ.

Нийт үндсэн хөрөнгийн 93.6 хувийг биет хөрөнгө, 6.4 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна. Биет бус хөрөнгийн эцсийн үлдэгдэл 11,574.3 сая төгрөг болж өмнөх оноос 75.4 сая төгрөгөөр өссөн бөгөөд 1.7 хувийг программ хангамж, 98.3 хувийг газар буюу бусад биет бус хөрөнгө эзэлж байна.

Хүснэгт 15. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл (сая төгрөг)

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Хувь
Барилга байгууламж, орон сууц	102,009.00	106289	4,280.00	58.6%
Тээврийн хэрэгсэл	8,957.10	9,532.40	575.30	5.3%
Машин тоног төхөөрөмж	13,766.10	14436.8	670.70	8.0%
Тавилга эд хогшил	3,381.50	3,513.10	131.60	1.9%
Зам гүүрний барилга байгууламж	5,629.50	5687.5	58.00	3.1%
Түүх соёлын дурсгалт зүйл	7.8	7.80	0.00	0%
Дуусаагүй барилга байгууламж	636.3	20.6	(615.70)	0%
Номын фонд	46	46.40	0.40	0%
Бусад үндсэн хөрөнгө	22,078.80	30124.3	8,045.50	17%
Программ хангамж	189.4	197.80	8.4	0.1%
<b>Бусад биет бус хөрөнгө</b>	<b>11309.5</b>	<b>11376.5</b>	<b>67.0</b>	<b>6.3%</b>

<b>Дүн</b>	<b>168,011.0</b>	<b>181,232.2</b>	<b>13,221.2</b>	<b>100%</b>
------------	------------------	------------------	-----------------	-------------

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2,676.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 7,233.9 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст, 1,742.2 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн, 39.2 сая төгрөгийн хөрөнгө хандиваар, бусад эх үүсвэрээс 12,192.9 сая төгрөг, дахин үнэлгээний 312.7 сая төгрөгийн нэмэгдэл бүртгэж нийт 24,197.4 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, 10,975.9 сая төгрөгийн хөрөнгө хасагдсанаас 5,395.8 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 4,924.9 сая төгрөгийн хөрөнгийг актлан, бүтцийн өөрчлөлтөөр 60.0 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлж, 104.0 сая төгрөгийн автомашиныг дуудлага худалдаагаар худалдаж, 8 сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тооллогоор дутагдсан 315.3 сая төгрөгийн моторыг Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/376 тоот албан бичгээр данснаас хасаж, авлагаар бүртгэсэн, Баян-Овоо сумын ЗДТГ нь 60.0 сая төгрөгийг тээврийн хэрэгслийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн, 175.9 сая төгрөгийн дахин үнэлгээний дансны өөрчлөлтөөр хасагдсан байна.

Хүснэгт 16. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл (сая төгрөг)

Үзүүлэлт	Биет хөрөнгийн дүн	Биет бус хөрөнгийн дүн	Нийт хөрөнгийн дүн
<b>Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл</b>	<b>156,512.20</b>	<b>11,498.80</b>	<b>168,011.00</b>
<b>Нэмэгдсэн</b>	<b>24,082.60</b>	<b>114.80</b>	<b>24,197.40</b>
Худалдан авсан	2,661.00	15.50	2,676.50
Хандиваар	39.20		39.2
Шилжүүлэн авсан	7,205.5	28.30	7,233.9
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	1,693.0	49.20	1,742.2
Бусад	12,202.0	21.40	12,192.9
Дахин үнэлгээний нэмэгдэл	312.3	0.40	312.7
<b>Хасагдсан</b>	<b>10,936.60</b>	<b>39.30</b>	<b>10,975.90</b>
Худалдсан	103.80	0.20	104.00
Акталсан	4,924.7	0.20	4,924.9
Шилжүүлсэн	5,357.30	38.50	5,395.80
Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	60.00		60.00
Бусад	315.3		315.3
Дахин үнэлгээний хорогдол	175.50	0.40	175.90
<b>Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>169,658.20</b>	<b>11,574.30</b>	<b>181,232.50</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хандиваар 39.2 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байгаа нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” II, III шатны санхүүжилтээр гэрээний дагуу 13.4 сая төгрөгийн өртөг бүхий 5 нэр төрлийн цахим хурлын тоног төхөөрөмжийг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт, Баян-Өндөр сумын ЗДТГ-т “Green Pontam” ХХК-аас 12.4 сая төгрөгийн газар тариалангийн төхөөрөмж, Байгаль орчин аялал, жуулчлалын яамнаас 13.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж хандиваар ирсэнтэй холбоотой байна.

Шилжүүлэн авсан гэсэн орлогын зүйлээр тайлант онд 7,233.9 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн 1,207.0 сая төгрөгийн лабораторийн барилга, Шинэ суурьшлын бүсийн цахилгааны дэд станц, ОНХС-ийн эх үүсвэрээс хийгдсэн гэрэлтүүлгийн ажлууд, Баянговь сумын ЗДТГ-ын 1,179.5 сая төгрөгийн ЗДТГ-ын шинэ барилга, Залаа 3 дугаар багийн барилга, худаг уст цэг, Баян-Өндөр сумын ЗДТГ-т 781.6 сая төгрөгийн хуучин эмнэлгийн засвар, багийн төвийн барилга, Онцгой байдлын Ерөнхий газар, аймгийн онцгой комиссоос олгосон тээврийн хэрэгсэл, Баянхонгор сумын ЗДТГ-т 784.4 сая төгрөгийн хөрөнгө зэргийг үнэ төлбөргүй бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр гэсэн орлогын зүйлээр тайлант онд 1,742.2 сая төгрөг нэмэгдсэн нь 4 өрхийн эмнэлгийн 1,695.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023.11.30-ны өдрийн “Үндсэн хөрөнгө

балансаас баланст шилжүүлэх тухай" 623 дугаар тогтоолоор Байгаль орчин аялал жуулчлалын газарт 34.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг, Баянхонгор сумын ИТХ-д 15.5 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн бусад хэсэгт 12,192.9 сая төгрөг нэмэгдсэн нь "Баянхонгор Тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-т уул уурхайн хандив, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5,430.2 сая төгрөгийн зам, талбай болон ариун цэврийн байгууламж, үерийн хамгаалалт, явган зам, багуудын тоглоомын талбайн тоног төхөөрөмж, замын бродюр, хашлага, аймгийн Орон нутгийн өмчийн газарт Чандмань Баянхонгор" ХК-аас 2,653.6 сая төгрөгийн өртөг бүхий "Хонгор 1000" дулааны зуухны барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг балансаас баланст шилжүүлсэн, ОНХС-ийн эх үүсвэрээр Жинст сумын ЗДТГ-т 483.8 сая төгрөгийн барилга, барилгын сайжруулалт, аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр Баянцагаан сумын ЗДТГ-т 772.9 сая төгрөгийн барилгын сайжруулалт, тээврийн хэрэгсэл, бусад хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн зэрэг нь нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Дуусаагүй барилга дансанд өмнөх онд 5 байгууллагын 636.3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байснаас тайлант онд "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-ийн 615.4 сая төгрөгийн өртөг бүхий барилга, Чандмань Баянхонгор ХК-ны 0.3 сая төгрөгийн дуусаагүй барилгыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн бөгөөд тайлант оны эцэст 3 байгууллагын 20.6 сая төгрөгийн хөрөнгө дуусаагүй үйлдвэрлэл дансанд үлдэгдлээр байна.

Дуусаагүй барилга дансны эцсийн үлдэгдэлд Баян-Овоо сумын хуучин спорт заалны барилга 5.8 сая, Өлзийт сумд төсвийн хөрөнгө оруулалтаар 7.4 сая төгрөгийн хүүхдийн тоглоом, Хүрээмарал сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн 7.4 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгт хүрээлэн зэрэг ажлууд бүртгэлээр үлдэгдэлтэй байна.

Тайлант онд Баянлиг сумын ЗДТГ 25.6 сая, Баянлиг сумын ИТХ 3.8 сая, Баянцагаан сумын ЗДТГ 198.7 сая, Байгаль орчин аялал, жуулчлалын газар 47.4 сая, Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ 37.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн байна.

#### Аудитын илрүүлэлт:

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 25.9 сая төгрөгийн хандиваар ирсэн хөрөнгийг шилжүүлэн авснаар, 29.7 сая төгрөгийн дутагдсан моторыг хөрөнгөөс хасаж, авлагаар бүртгэсэн байхад акталсан ангиллаар, Баянцагаан сумын ЗДТГ-ын 198.7 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээг хийсэн байхад бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авснаар, "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын ОНХС-ийн эх үүсвэрээр бий болсон 15.0 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар авсан ангиллаар тус тус бүртгээснийг аудитын явцад залруулав.

#### 3.4.8 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт байхгүй байна.

#### 3.4.9 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 13,037.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 10,253.1 сая төгрөг болж, 2,784.2 сая төгрөгөөр буурсан байна. Үүнээс богино хугацаат өр төлбөр 4,306.4 сая төгрөг болж өмнөх оноос 1,662.2 сая төгрөгөөр буурсан ба нийт өр төлбөрийн 42.0 хувийг богино хугацаат өр төлбөр, 58.0 хувийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна.

Хүснэгт № 17. Нийт өр төлбөрийн үлдэгдэл (сая төгрөг)

Ангилал	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), бууралт (-)	Хувь
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>5,968.6</b>	<b>4,306.4</b>	<b>(1,662.2)</b>	<b>42.0</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	15.6	22.9	7.3	0.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	683.6	428.4	(255.2)	10.0
Байгууллагад өгөх өглөг	4,436.8	3,521.6	(915.2)	81.8
Хувь хүмүүст өгөх өглөг	0.8	0.7	(0.1)	0.0
Татварын өглөг /ТӨҮГ/	225.7	161.8	(63.9)	3.8
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	2.3	2.6	0.3	0.0
Дансны өглөг /ТӨҮГ/	2.4	1.3	(1.1)	0.0
Урьдчилж олсон орлого	601.5	167.1	(434.4)	3.9
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>7,068.7</b>	<b>5,946.7</b>	<b>(1,121.9)</b>	<b>58.0</b>
<b>Төгрөг</b>	<b>6,559.7</b>	<b>5,518.3</b>	<b>(1,041.4)</b>	<b>92.2</b>
Хувь хүмүүсийн зээл	2,062.4	1,817.9	(244.5)	30.6

Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	4,497.3	3,660.3	(837.0)	61.6
<b>Гадаад валют</b>	<b>509.0</b>	<b>468.5</b>	<b>(40.5)</b>	<b>7.8</b>
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	509.0	468.5	(40.5)	7.8
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>13,037.3</b>	<b>10,253.1</b>	<b>(2,784.2)</b>	<b>100.0</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр:</b>				
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>5,968.6</b>	<b>4,306.4</b>	<b>(1,662.2)</b>	<b>42.0</b>
Төсөвт байгууллага	373.1	429.3	56.2	10.1
Төсөл/сан	4,278.5	3,291.2	(987.3)	76.4
Төрийн сан	448.3	-	(448.3)	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	868.7	585.9	(282.8)	13.6
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>7,068.7</b>	<b>5,946.7</b>	<b>(1,081.4)</b>	<b>58.0</b>
Төсөвт байгууллага	4,335.0	3,570.7	(764.3)	60.0
Төсөл/сан	-	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,733.7	2,376.0	(357.7)	40.0
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>13,037.3</b>	<b>10,253.1</b>	<b>(2,784.2)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### Богино хугацаат өр төлбөр:

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн 10.1 хувь буюу 429.3 сая төгрөгийн өглөг нь төсөвт байгууллагын, 76.4 хувь буюу 2,542.2 сая төгрөг нь техник хяналт, барьцаа данс, 521.5 сая төгрөг нь Баянхонгор аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн өглөг, 227.5 сая төгрөг нь Галуут, Баян-Овоо, Жаргалант, Баянговь, Гурванбулаг, Бөмбөгөр, Хүрээмарал, Баянхонгор сумын орон нутгийн хөгжлийн сангийн өглөг байна.

Нийт богино хугацаат өр төлбөрийн 13.6 хувь буюу 585.9 сая төгрөг нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид буюу “Баянхонгор-Эрчим Хүч” ХХК 200.6 сая, “Чандмань Баянхонгор” ХК 8.3 сая, “Баянхонгор үйлдвэржилт корпорац” ХХК-ны 217.6 сая, Ингэн эрдэнэ ОНӨААТҮГ 17.2 сая, Цэвэр хот 102.2 сая, Баян-Өсөх Агро ОНӨААТҮГ-ын урт хугацаат зээлийн ангиллаар бүртгэгдсэн 40.0 сая төгрөгийг өглөгийн үлдэгдэл байна.

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат үнэт цаас, богино хугацаат зээл байхгүй ба урьдчилж орсон орлого нь “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн төсөл хөтөлбөрт олгосон зээлээс суутгасан хяналтын зардал 153.9 сая, түрээслэгчдээс урьдчилж авсан нэг сарын түрээсийн төлбөр 13.4 сая, нийт 167.0 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг бүртгэсэн байна.

### Урт хугацаат өр төлбөр:

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл оны эхэнд 7,068.7 сая төгрөг байсан ба тайлант онд 1,121.9 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, оны эцэст 5,987.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

#### Хүснэгт 18. Урт хугацаат өр (сая төгрөг)

Байгууллагын нэр	Зээлийн эх үүсвэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн дүн	Хорогдсон дүн	Эцсийн үлдэгдэл
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>7,068.7</b>	-	<b>1,121.9</b>	<b>5,946.7</b>
<b>Урт хугацаат зээл</b>		<b>7,068.7</b>	-	<b>1,121.9</b>	<b>5,946.7</b>
<b>Төгрөг</b>		<b>6,559.7</b>	-	<b>1,081.4</b>	<b>5,478.3</b>
Чандмань Баянхонгор ХК	Азийн хөгжлийн банк, Сангийн яам, ЗДТГ-ын дамжуулан зээлдүүлэх Мон-1847 зээл	122.3		32.7	89.6
Аймгийн ОНӨГ	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлтэй Мон-2301 төслийн зээл	4,335.0		764.3	3,570.7
Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн Корпораци ХХК	Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/	1,557.5		244.4	1,313.1
	Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/	429.4			429.4
	Төрийн сан /ангилагдаагүй зардал жимс жимсгэнэ тариалах/	0.5			0.5
	Төрийн сан /ЖДҮ-ийн эргэн төлөлт/	75.0			75.0
Баян-Өсөх Агро ОНӨААТҮГ	Санхүүжилт	40.0		40.0	-
Гадаад валют		<b>509.0</b>	-	<b>40.5</b>	<b>468.4</b>

Баянхонгор Эрчим Хүч ЦТХХК	Азийн хөгжлийн банк, Сангийн яам, ЗДТГ-ын дамжуулан зээлдүүлэх Мон-1847 зээл	15.7	4.0	12.2
Баянхонгор Эрчим Хүч ЦТХХК	Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээл MOG-3503	493.3	36.5	456.2

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн дүн 1,081.4 сая төгрөгөөр буурсан нь “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК нь Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй МОН-1847 зээлээс 4.0 сая, Дэлхийн банкны санхүүжилтээр олгосон МОН-3503 зээлээс 36.5 сая төгрөг, “Чандмань-Баянхонгор” ХК нь МОН-1847 төслийн зээлээс 32.7 сая төгрөгийг барагдуулсан байна. Дээрх төслийн зээлийн хүүгийн төлбөрт 14.7 сая төгрөгийг төлсөн байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй МОН-2301 төслийн зээлийн хүрээнд ангилагдаагүй зардлаас 604.6 сая төгрөгийг төлж, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 350.0 сая, аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 12.4 сая төгрөгийг суутган тооцож нийт 967.1 сая төгрөгийг төлснөөс хүүгийн зардалд 202.8 сая, үндсэн зээлээс 764.3 сая төгрөг тус тус хасагдсан байна.

“Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ийн үйл ажиллагаа жигдрээгүй, аймгийн ИТХ-ын шийдвэрээр 40.0 сая төгрөгийн өр төлбөрийг хүдэр баяжуулах цехийн орлогоос авч санхүүжсэн боловч тус өр төлбөрийг хэзээ буцаан төлөх нь тодорхойгүй байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

“Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ийн 40.0 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийг урт хугацаат зээлийн ангиллаар бүртгэснийг аудитын явцад залруулсан.

#### **3.4.10 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 141,758.0 сая, эцсийн үлдэгдэл 155,865.8 сая төгрөг болж, өмнөх оноос 14,107.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 19. Хуримтлагдсан үр дүн (сая төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	52,363.7	53,741.3	1,377.6	34.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,472.9	17,148.5	(324.4)	11.0
Хуримтлагдсан үр дүн	71,921.3	84,976.0	13,054.7	54.5
<b>Дүн</b>	<b>141,758.0</b>	<b>155,865.8</b>	<b>14,107.8</b>	<b>100.0</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			-	
Төсөвт байгууллага	101,789.1	116,077.9	14,288.9	74.5
Төсөл/ сан	442.0	1,056.1	614.1	0.7
Төрийн сан	6,672.9	6,087.2	(585.7)	3.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	32,854.0	32,644.6	(209.4)	20.9
<b>Дүн</b>	<b>141,758.0</b>	<b>155,865.8</b>	<b>14,107.8</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс нь үндсэн хөрөнгийн өсөлт 1,377.6 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүн 13,054.7 сая төгрөгөөр өсөж, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс 324.4 сая төгрөгөөр буурсан байна.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулгын данс дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгө шилжиж ирсэн мөн акталсан, үндсэн хөрөнгийг үлдэгдэл залруулсан, өмнөх оны үндсэн хөрөнгийн элэгдэл, өглөг, авлагыг зөрүүтэй тооцсон зэргээр 1,450.6 сая төгрөгөөр өмнөх үеийн үр дүнг нэмэгдүүлсэн байна.

#### **ТӨҮГ болон ОНӨҮГ хувьд эздийн өмч дансанд гарсан өөрчлөлт**

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот 7 байгууллагын санхүүгийн тайланд хуримтлагдсан үр дүн -1,193.7 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

Хүснэгт 20. ОНӨААН-ийн хуримтлагдсан үр дүн (сая төгрөг)

№	ААН нэр	тоо	Орлого	Зарлага	2023 оны үр дүн	Өмнөх үеийн үр дүн	Хуримтлагдсан үр дүн
1	“Баянхонгор Эрчим хүч” ХХК	1	14,521.5	14,243.6	277.3	(692.5)	(414.6)
2	“Чандмань Баянхонгор” ХК	1	3,553.1	3,798.9	(245.8)	509.2	263.5
3	“Цэвэр хот” ОНӨҮГ газар	1	860.6	991.2	(130.6)	(15.4)	(146.0)

4	“Үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК	1	230.9	458.9	(228.0)	(1,032.3)	(1,260.3)
5	“Ингэн эрдэнэ” ОНӨААТҮГ	1	262.0	49.1	212.9	(17.2)	195.7
6	“Баян есөх агро” ОНӨААТҮГ	1	1.0	1.0	(0.0)	147.5	147.4
7	Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	1	215.6	227.1	(11.5)	32.0	20.5
	<b>ДҮН</b>	<b>7</b>	<b>19,644.7</b>	<b>19,769.6</b>	<b>(125.5)</b>	<b>(1,068.8)</b>	<b>(1,193.7)</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд “Баянхонгор Эрчим хүч” ХХК, “Ингэн эрдэнэ” ОНӨААТҮГ-аас бусад орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газрууд алдагдалтай ажиллажээ.

### 3.5.3. Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 5 байгууллага 37.7 сая, дээд шатны төсвийн захирагчаас 38 байгууллага 1,338.9 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 23 байгууллага 1,263.4 сая, нийт 2,640.0 сая төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 1 байгууллага 0.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 46 байгууллага 2,087.0 сая, бараа, ажил үйлчилгээний зардалд 1 байгууллага 12.2 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардалд 1 байгууллага 40.0 сая, хөрөнгийн зардалд 1 байгууллагад 0.6 сая, нийт 2,140.4 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдлийн 499.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Тус аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа ахлан аудитор Б.Нарангэрэл, Н.Бүнчинсүрэн, Б.Наранцэцэг нар гүйцэтгэж хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1а/229 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн

санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 146.5 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 732.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 476.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас төсвийн шууд захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 124 байгууллагыг хамруулан гүйцэтгэсэн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 18.3 сая төгрөгийн 14 зөрчил илэрснээс 12.7 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 4.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага өгч, 1.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт 21. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчил (сая төгрөг)

Он	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийт зөрчил	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2022	26	21.0	17	56.2	14	143.6	57	220.8
2023	12	12.7	1	4.0	1	1.6	14	18.3
<b>Өөрчлөлт</b>	<b>(14)</b>	<b>(8.3)</b>	<b>(16)</b>	<b>(52.2)</b>	<b>(13)</b>	<b>(142.0)</b>	<b>(43)</b>	<b>(202.5)</b>

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэлийн судалгаа

Нийт зөрчлийн дүн өмнөх оноос 202.5 сая төгрөгөөр буюу 91.7 хувиар буурсан байна. Алдаа зөрчлийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтаар нь авч үзвэл нийт зөрчлийн 24.3 хувь нь 12 дугаар зүйлийг, 60 хувь нь 15 дугаар зүйлийг, 15.7 хувь нь бусад заалтыг зөрчсөн байна.

Хүснэгт 22. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчил (сая төгрөг)

Зөрчсөн заалтын дугаар	Хуулийн заалт	Тоо	Дүн
TXX 12.1.1.	12.1.1.гар утасны зардал;	1	0.4
TXX 12.1.4.	12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад.	3	4.0
TXX 15.1.3.	15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;	4	6.6
TXX 15.1.5.	15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;	1	0.2
TXX 15.2.3.	15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;	3	4.2
TXX 6.2.	6.2.Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.	1	2.7
TXX 8.1.	8.1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.	1	0.2
	<b>Дүн</b>	<b>14</b>	<b>18.4</b>

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2022, 2023 оны зөрчлийн нэгтгэсэн судалгаа

#### 4.6 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.6.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 121 мэдээллийг хугацаанд нь, 33 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг байршуулах хуулийн хугацаа болоогүй байна.

##### Хүснэгт 23. Шилэн дансны мэдээлэл

Д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй	Хугацаа болоогүй	Хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	12	12	6	3	-	3	ТЕЗ-ийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, Дараа жилийн төсвийн төсөл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн
2	Хагас жил	1	1	1		-		-
3	Сар бүр	6	72	42	30	-		Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 2,3,5,6,7,9,10,12 сарууд хугацаа хоцроосон, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл 2,3, 5-10 сар,12 сар, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 2,8,11 сард, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл 7,8,9 сар, Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл 7,8 сар, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт 1,4,7,8,9 сарын мэдээг хоцроож байршуулсан.
4	Тухай бүр	6	72	72		-		-
<b>Нийт</b>		<b>25</b>	<b>157</b>	<b>121</b>	<b>33</b>	<b>-</b>	<b>3</b>	

Эх сурвалж. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудас

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-т хамаарах орон нутгийн өмчит 114 төсөвт байгууллага, 3.1.3-т хамаарах орон нутгийн өмчит 5 аж ахуйн нэгж, 3.1.5-т хамаарах төсвөөс санхүүжилт авч байгаа, 4 өрхийн эмнэлэг, нийт 123 төсвийн байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагдаж, мэдээллийг байршуулж иржээ.

##### Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 124 мэдээллийг хугацаанд нь, 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа "Мэлтэс Оргих" ХХК, "Монгол болгар гео" ХХК, аймгийн Засаг дарга нарын хооронд 2023 онд байгуулсан "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"-г шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн Засаг даргын харьяа 123 байгууллагын Шилэн дансны цахим хуудаст мэдээлсэн байдлыг шалгахад аудитаар нийт 4,702.9 сая төгрөгийн 28 алдаа зөрчил илэрсэнд санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 31.5 сая төгрөгийн мэдээллийг нөхөн байршуулж залруулсан бөгөөд зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 60.6 сая төгрөгийн 3 зөвлөмж, зөрчлийг арилгах 4,610.8 сая төгрөгийн 22 албан шаардлагыг хүргүүлж ажилласан.

#### 4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 123 байгууллагыг хамруулан гүйцэтгэсэн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын эзэмшил /өмчлөл/-д байгаа газрын судалгааг гаргуулан авч гэрчилгээ, кадастрын зурагтай тулган баталгаажуулалт хийхэд байгууллагын хөрөнгөд бүртгээгүй, эзэмшил өмчлөлд байгаа газрын хэмжээ зөрүүтэй зэрэг 1.6 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн байна.

Хүснэгт 24. Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл (сая төгрөг)

Д/д	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Зөрчлийг арилгах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн ЗДТГ	1	-	1	-
2	Баянхонгор тохижилт үйлчилгээний газар	1	-	1	-
3	Чандмань- Баянхонгор ХК	1	-	1	-
4	Баянхонгор сумын ЗДТГ	1	-	1	-
5	Баян-Овоо сумын ЗДТГ	1	-	1	-
6	Баян-Өндөр сумын ЗДТГ	1	1.6	1	1.6
7	Богд сумын ЗДТГ	1	-	1	-
8	Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газар	1	-	1	-
9	Баянговь сум Засаг даргын Тамгын газар	1	-	1	-
10	Жинст сумын ЗДТГ	1	-	1	-
11	Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ	1	-	1	-
12	Хүрээмарал сумын ЗДТГ	1	-	1	-
13	Өлзийт сумын ЗДТГ	1	-	1	-
<b>НИЙТ ДҮН</b>		<b>13</b>	<b>1.6</b>	<b>13</b>	<b>1.6</b>

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэсэн судалгаа

Аудитаар Үндэсний аудитын газраас 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 07/768 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих чиглэлээр “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-аар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгож буй асуудлыг эрсдэл болгон авч үзлээ.

Баянхонгор аймгаас жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих чиглэлээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 97 дугаар тогтоолоор “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийн санхүүжүүлэх журам” баталжээ. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2019 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Баянхонгор аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн 2012-2016 онд олгосон зээлийн хөрөнгийг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн харьяанд шилжүүлэн ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийг олгож ирсэн байна. Аймгийн ИТХ-аас 2020-2022 онд “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийн санхүүжүүлэх журам”-д 2 удаа өөрчлөлт оруулан зээлийн хэмжээг аж ахуйн нэгж байгууллагад “100 сая хүртэлх” гэснийг “300.0 сая болгон өөрчилж, зээлийн жилийн хүүг 3 (гурав) хувь байхаар шинэчлэн тогтоосон байна.

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК нь 2023 онд 15 орон тоогоор ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох мөн Ажилсаг төв, Ахуйн үйлчилгээний төвийн ажлын байрыг түрээслүүлэх үйл ажиллагааг явуулж байна.

Баянхонгор аймгийн орон нутгийн төсвөөс 2020-2023 онд хөнгөлөлттэй зээл олгохтой холбоотой санхүүжилт олгоогүй, харин Дэлхий нийтэд Ковид-19 цар тахал гарсантай холбоотой 2021 онд ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд 50.0 сая төгрөгийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ангилагдаагүй зардлаас олгосон байна.

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК нь 2023 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 75.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 1,804.9 сая төгрөгийн авлага, 3,243.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна.

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл 1,804.9 сая төгрөг байгаагаас 1,785.8 сая төгрөг нь ЖДҮ эрхлэгчдэд олгосон хөнгөлөлттэй зээлийн авлага бөгөөд үүнээс 685.3 сая төгрөгийн зээлийн авлага хугацаа хэтэрсэн байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар жил бүр зээлийн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах талаар төлбөрийн акт, албан шаардлагыг хүргүүлж, аймгийн Засаг даргын 2021-2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар аймгийн ИТХ-д дараах 2 асуудлыг толилуулсан байна. Үүнд:

- “Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ажлын үр дүн, төлөөлөн удирдах зөвлөлийн баталж байгаа үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ИТХ-ын Хуралдаанаар авч хэлэлцэн менежментийн асуудалд анхаарал хандуулж шийдвэр гаргах”
- “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн алдагдал сүүлийн жилүүдэд нэмэгдэж 2022 оны эцэст 332.3 сая буюу хуримтлагдсан алдагдал 1,032.3 сая төгрөг хүрсэн тул үйл ажиллагааны үр дүнг нь нэн даруй хэлэлцэж, цаашид ямар хэлбэрээр орон нутгийн хөгжлийг дэмжих талаар шийдвэр гаргах шаардлагатай байна” гэж толилуулан ажилласан байна.

#### Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн ИТХ-аас “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийн санхүүжүүлэх журам” баталсан нь Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь “Сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журмыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16.7-д заасны дагуу Засгийн газар батална” гэсэн заалттай, ОНӨААН нь тус журмын дагуу хөнгөлөлттэй зээл олгож байгаа нь Тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь “Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжихэд олгож буй хөнгөлөлттэй зээлийг ЖДҮҮДэмжих тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, бусад хууль, тогтоомжид нийцүүлэх олгох талаар аймгийн ИТХ-д хүргүүлэв.

#### 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.7.1 Завсрын аудитын талаар

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсар үеийн аудит хийгээгүй болно.

##### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 925.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 925.0 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулан бүртгэж, 3 албан шаардлага өгч, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 4 заалт бүхий зөвлөмжийг өгсөн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжилтийг 2023 оны 09 дүгээр сарын 14 өдрийн 1а/808 тоот албан бичгээр, 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 1а/995 тоот албан бичгүүдээр ирүүлснийг аудитаар тооцоход албан шаардлагыг дунджаар 84.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт:25 Өмнөх оны албан шаардлагын хэрэгжилт

№	Аудитаар өгсөн албан шаардлага	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	Аудитаар тооцсон биелэлт
1	Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа	2024 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 1а/808 тоот албан бичгээр албан	Хагас жилээр санхүүгийн тайланд авлагын

№	Аудитаар өгсөн албан шаардлага	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	Аудитаар тооцсон биелэлт
	төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тус байгууллагууд нь авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байхад тооцоо нийлсэн актгүйгээр бүртгэсэн, мөн тайлант онд үүссэн болон 5-аас бага жилийн насжилттай авлагын насжилтыг буруу бүртгэсэн мөн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг дутуу бүртгэсэн зэргээр нягтлан бодогч нар э-тайланд авлагын тодруулгыг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй байхад түүнд хяналт тавиагүй байна.	шаардлага, зөвлөмжийн төлөвлөгөө биелэлтийг нотлох баримтын хамт ирүүлсэн.	насжилтыг залруулан бүртгэсэн ч жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулга тайланд авлагын насжилтыг буруу ангилж бүртгэсэн байна.  <b>Биелэлт 85%</b>
2	Төсөвт байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглаж байсан 44 автомашиныг аймгийн Орон нутгийн өмчийн газарт татан төвлөрүүлж аймгийн Засаг даргын 2023.03.20-ны өдрийн А/147 дугаар захирамжаар 20 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, 6 автомашиныг акталж, 10 автомашиныг автомашин дутагдалтай төсөвт байгууллагуудад балансаас баланст шилжүүлэхээр шийдвэрлэснээс 28 байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 34 тээврийн хэрэгслийг Орон нутгийн өмчийн газарт 2023.03.25-ны өдрийн байдлаар ирүүлээгүй байна.	2023 онд татан төвлөрүүлээгүй 26 тээврийн хэрэгслийг Орон нутгийн өмчийн хашаанд төвлөрүүлж, Аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэр гаргуулж ажиллах талаар Орон нутгийн өмчийн газарт албан тоот хүргүүлсэн. Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2023 оны 09 дүгээр сарын байдлаар нийт 26 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлж, дуудлага худалдаагаар худалдан борлуулж, 211,6 сая төгрөгийг төвлөрүүлж ажилласан.Татан төвлөрүүлээгүй 8 тээврийн хэрэгсэл байна.	Өмнөх аудитаар Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын “Албан тушаалын, албан ажлын суудлын автомашины тоо, төрөл, автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг баталж журмаар зөвшөөрөгдөөгүй нийт 78 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлж Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн бөгөөд одоогоор 5 сумын 209.7 сая төгрөгийн балансын үнэ бүхий 8 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ. <b>Биелэлт 89.7%</b>
3	Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 156 мэдээллээс 84 мэдээллийг хугацаанд нь, 57 мэдээллийг хугацаа хоцроож, 13 мэдээллийг мэдээлээгүй байна.	ТЕЗ-ийн шилэн дансны мэдээлэл оруулах төлөвлөгөөг гарган Санхүү, төрийн сангийн хэлтсээр батлуулан ажиллах талаар 2024 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 1а/808 тоот албан бичгээр ирүүлсэн. 2023.05.25-ны өдөр аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах, тайлагнах төлөвлөгөөг гаргаж СТСХ-ийн дарга С.Байгалмаагаар батлуулсан боловч нотлох баримтыг ирүүлээгүй. Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 121 мэдээллийг хугацаанд нь, 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 121 мэдээллийг хугацаанд нь, 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна <b>Биелэлт 77%</b>
<b>БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ</b>			<b>84.0%</b>

Өмнөх оны аудитаар нийт 4 заалт бүхий зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж 95.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

№	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	Аудитаар тооцсон биелэлт
1	Орон нутгийн өмчит хуулийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.	“Жаргалтай амьдрал” төв ОНӨААТҮГ, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК, “Чандмань-Баянхонгор” ХК, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК байгууллагуудад албан хаагчид олгох цалин хөлсний жишгийг тогтоож, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах тухай албан тоотыг хүргүүлсэн гэх боловч цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулаагүй байна.	“Цэвэр хот” ОНӨААТҮГ, “Жаргалтай амьдрал” төв ОНӨААТҮГ, -ын цалин хөлсийг аймгийн ИТХ-аар, харин бусад орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын цалин хөлсийг ТУЗ-аар хэлэлцүүлэн батлуулж байна. <b>Биелэлт 80%</b>

№	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	Аудитаар тооцсон биелэлт
2	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгийн эзэмшигчийг тогтоох асуудлыг цаг тухайд нь эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлж байх.	2023 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 1а/808 тоот албан бичгээр албан шаардлага зөвлөмжийн төлөвлөгөө, биелэлтийг нотлох баримтаар ирүүлсэн.	Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/11 тоот" Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай" тогтоолоор Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, орон нутгийн аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн 342 нэр, төрлийн 29,255.4 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг орлого авах шийдвэр гарсан. <b>Биелэлт 100%</b>
3	Богд сумын ЗДТГ, ИТХ нь Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу төсөвт байгууллагууд нь санхүүгийн тайлангаа хугацаанд нь ирүүлж байх, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас хяналт хэрэгжүүлж байх.	Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн тамгын газрын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 2/1311 тоот албан бичгээр Богд сумын засаг даргын тамгын газарт Ч.Долгорсүрэнтэй туршилтын 3 сарын хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллахыг зөвлөсөн. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Сан, Эрүүл мэндийн төвд шинээр томилгодож байгаа нягтлан бодогчдыг Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын дагуу зөвшилцөн ажиллаж байна.	Ирүүлсэн нотлох баримтыг аудитаар тооцов. <b>Биелэлт 100%</b>
4	Орон нутгийн өмчийн хөрөнгийг цаашид хэрхэн бүртгэх талаар шийдвэрийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.	2023 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 1а/808 тоот албан бичгээр албан шаардлага зөвлөмжийн төлөвлөгөө, биелэлтийг нотлох баримтаар ирүүлсэн.	Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд бүртгэлтэй 4 өрхийн эмнэлгийн нийт 1,460.6 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий хөрөнгийг 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гаргалтаар залруулан бүртгэж, санхүүгийн нэгтгэсэн тайланд орлого авсан. <b>Биелэлт 100%</b>
<b>БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ</b>			<b>95%</b>

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

#### Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 49 төсвийн байгууллага, 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төв, 42 тусгай сан, 20 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нийт 122 байгууллагын санхүүгийн тайлан болон ангилагдаагүй зардал, замын сан, хяналтын барьцаа данс, засаг даргын нөөц хөрөнгийн данс нийт 5 дансны гүйлгээ нэгтгэгдсэнээс 122 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулж 50 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 72 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан бөгөөд “Баян өсөх агро” ОНӨААТҮГ аудитад хамрагдаагүй байна.

Хүснэгт 26. Харьяа байгууллагуудын дүгнэлтийн хэлбэр (тоогоор)

Ангилал	Дүгнэлт өгсөн			Түүвэрт хамрагдсан	Аудитад хамрагдаагүй	Нийт
	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг			
ТЕЗ	1					1
ТТЗ	19	1				20
ТШЗ	13	7	1	28		49
Тусгай сан				42		42
ОНӨААН	3	1		2	1	7
Өрхийн эмнэлэг	4					4
<b>Нийт</b>	<b>40</b>	<b>9</b>	<b>1</b>	<b>72</b>	<b>1</b>	<b>123</b>

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэлийн судалгаа

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 72 байгууллагыг түүвэрт хамруулж, 50 байгууллагад дүгнэлт хүргүүлснээс 39 байгууллагад “Өөрчлөлтгүй”, 10 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 11,852.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,298.4 сая төгрөгийн 66 алдааг санхүүгийн тайланд залруулж, 146.1 сая төгрөгийн зөрчилд 52 төлбөрийн акт тогтоож, 7,985.3 сая төгрөгийн зөрчилд 128 албан шаардлага хүргүүлж, 1,422.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй 42 зөвлөмжийг хүргүүлж, 4 албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг томилсон эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж ажиллав.

Нийт алдаа, зөрчлийн 60.3 хувь буюу 7,149.3 сая төгрөг нь санхүүгийн тайлагналын алдаа, 39.7 хувь буюу 4,703.2 сая төгрөгийн алдаа, зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын алдаа, зөрчил эзэлж байна.

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчлийг өмнөх онтой харьцуулбал нийт алдааны дүн 6,396.5 сая төгрөгөөр өссөн байгаа нь санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүйд илэрсэн зөрчлийг мөнгөн дүнтэй авсан нь голлох нөлөөг үзүүлжээ.

Хүснэгт 27. Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл (сая төгрөг)

Он	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Залруулагдаагүй алдааны дүн	Санхүүгийн тайланд залруулсан алдааны дүн	Нийт алдааны дүн
2021	381.6	2,391.4	8,559.7	11,332.7	1,083.1	12,415.8
2022	258.0	1,797.8	2,787.1	4,842.8	613.2	5,456.0
2023	146.1	7,985.3	1,422.7	9,554.1	2,298.4	11,852.5
<b>Өөрчлөлт</b>	<b>(111.9)</b>	<b>6,187.5</b>	<b>(1,364.4)</b>	<b>4,711.3</b>	<b>1,685.2</b>	<b>6,396.5</b>

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэлийн судалгаа

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар:

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 19 байгууллагад “Өөрчлөлтгүй”, Бууцагаан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Хүснэгт 28. Хязгаарлалттай дүгнэлт авсан төсвийн төвлөрүүлэн захирагч

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
<b>"ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"</b>	
<b>БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГА</b>	-Сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт алдаа зөрчил нь гүйцэтгэлийн материаллаг байдлаас давсан; - Бууцагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас 1 байгууллага “Сөрөг” дүгнэлт авч, нийт 487.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 121.0 сая төгрөгийн 6 алдааг санхүүгийн тайланд залруулж, 12.8 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 256.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 97.2 сая төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлсэн;

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
	<ul style="list-style-type: none"> <li>- Тус сумын сум хөгжүүлэх сангаас зээл авсан 5 зээлдэгчийн 11.2 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ч хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй;</li> <li>- Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар 0.4 сая, бууны татвар 0.3 сая, газрын дуудлага худалдааны орлого 7.2 сая, малын тоо толгойн албан татварын орлого 37.5 сая, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 0.6 сая төгрөгөөр тасарсан байна.</li> </ul>

Эх сурвалж: Төсвийн төвлөрүүлэн захирагч нарын аудитын тайлан, аудитын гэрчилгээ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,469.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 11.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3,356.4 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага хүргүүлж, 102.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 18 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах саналыг 1 албан тушаалтанд хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т нийцүүлэн бэлтгээгүй, сумдын орон нутгийн орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс орлогын төлөвлөгөө тасарсан зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн байна.

Төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн байгууллага, орон нутгийн тусгай сангийн 91 санхүүгийн тайланд аудит хийснээс 70 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 21 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгснөөс 12 байгууллагад “Өөрчлөлтгүй”, 8 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,484.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,906.6 сая төгрөгийн 60 алдааг залруулж, 131.1 сая төгрөгийн зөрчилд 48 төлбөрийн акт тогтоож, 3,937.9 сая төгрөгийн зөрчилд 96 албан шаардлага хүргүүлж, 508.9 сая төгрөгийн зөрчилд 21 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах саналыг 2 албан тушаалтанд хүргүүлсэн.

Хүснэгт 29. “Хязгаарлалттай” болон “Сөрөг” санал дүгнэлт авсан төсвийн шууд захирагч

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
<b>"ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"</b>	
<b>БАЯНХОНГОР АЙМГИЙН СУМ ДУНДЫН ОЙН АНГИ</b>	<ul style="list-style-type: none"> <li>-Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн;</li> <li>- Байгууллагын даргаар ажиллаж байсан П.Уртнасан 3.8 сая төгрөгийн 4 тонн улаан хивгийг эргэн төлөхөөр авсан байхад санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй, бараа материалын үлдэгдлээр тайлагнасан;</li> <li>-Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд бүртгэлтэй "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-тай холбоотой 74.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар анхаарч авч үзэх талаар санхүүгийн тайланд дурдсан байхад тус байгууллагаас ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна;</li> </ul>
<b>БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн;</li> <li>- Санхүүгийн тайланд анхан шатны баримтгүй гүйлгээ тусгасан;</li> <li>-Холбогдох байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлээгүйгээс байгууллагын санхүүгийн тайлангаас биет бус хөрөнгийг хасаагүй байна.</li> </ul>
<b>ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн;</li> <li>- Жилийн эд хөрөнгийн тооллогоор санхүүгийн тайланд бүртгэлтэй боловч биетээр байхгүй 49.6 сая төгрөгийн мал амьтдыг байгаагаар тоолсон;</li> <li>- Өмнөх оны санхүүгийн тайланд бүртгэлтэй нягтлан бодогчоор ажиллаж байсан А.Мөнхтогтохтой холбоотой авлагыг барагдуулаагүй байна;</li> </ul>
<b>БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн;</li> <li>- Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 45.0 сая төгрөгийн 2019 онд үндсэн хөрөнгөд бүртгэсэн хадлангийн трактор биетээр байхгүй;</li> <li>- Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийсэн тооллогын комисс бараа материалыг тоолоогүй;</li> <li>-Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг 2023 онд давтан гаргасан байна.</li> </ul>

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
<b>БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</b>	<ul style="list-style-type: none"> <li>-Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс 17.4 сая төгрөгөөр хэтэрсэн;</li> <li>- Тус байгууллага нь хамт олноороо хэлэлцэн “ЗДТГ-ын төрийн албан хаагч, ажилтан нарт буцалтгүй тусламж үзүүлэхэд мөрдөх журам” боловсруулан нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг зориулалт бусаар зарцуулсан;</li> <li>- Баянхонгор сумын ЗДТГ-ын албан хаагчид 14.2 сая төгрөгөөр гамшгаас хамгаалах болон байгаль орчны албан хаагчдад нормын хувцас хийлгэсэн, мөнгөн хөрөнгийн урьдчилгаагаар 30.7 сая төгрөгийн нярвын болон нийтлэг үйлчилгээний газрын даргын дансаар дамжуулан гүйлгээ хийсэн боловч кассын тайлан гаргаагүй, холбогдох анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.</li> </ul>
<b>БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн;</li> <li>- Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А08 дугаар захирамжаар дуучны цомгийн зардалд засаг даргын нөөц хөрөнгөөс 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна;</li> <li>- Засаг даргын нөөц хөрөнгөөс багийн эмч нарт нэг бүр нь 3.0 сая төгрөгийн үнэ бүхий 6.1 сая төгрөгийн 2 мотоцикл, хүүхдийн цэцэрлэгт 3.0 сая төгрөгийн ширээ, сандал авсан байна.</li> <li>- Тайлант хугацаанд өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүйгээр ланд-470 авто машинд 8.8 сая төгрөгийн мотор, 1.4 сая төгрөгийн дугуй авч сольж тавьсан бөгөөд сэлбэг хэрэгслийн дансанд үлдэгдлээр тайлагнасан байна</li> <li>-</li> </ul>
<b>БӨМБӨГӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</b>	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс 17.4 сая төгрөгөөр хэтэрсэн;</li> <li>- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас ан, агнуурын бүс нутгийн 2 газарт булаг, шандыг хашиж хамгаалах, сэргээн засварлах 30.0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэхдээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй;</li> <li>- Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөн ажиллаагүй;</li> <li>- Авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй;</li> <li>- Шилэн дансны мэдээллийг хугацаанд үнэн зөв мэдээлээгүй;</li> </ul>
<b>БОГД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</b>	<ul style="list-style-type: none"> <li>-Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5.4 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшин 4.5 сая төгрөгөөс хэтэрсэн;</li> <li>- цалингаас хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй;</li> <li>- Ур чадварын нэмэгдлийг зөрүүтэй тооцож олгосон;</li> <li>- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 0.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;</li> </ul>
<b>"СӨРӨГ" САНАЛ ДҮГНЭЛТ</b>	
<b>БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</b>	<ul style="list-style-type: none"> <li>-Аудитаар илэрсэн 322.3 сая төгрөгийн нийт алдаа, зөрчил нь төлөвлөлтийн шатанд урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшин болох 7.4 сая төгрөгөөс хэтэрсэн;</li> <li>- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 2.7 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан</li> <li>- Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа 24.9 сая төгрөгийг байгууллагын нярвын дансаар дамжуулан гүйлгээ хийсэн бөгөөд зарцуулалтын тайланг гаргаагүй, 30.7 сая төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримтаар нотлогдоогүй;</li> <li>- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулж буй 8.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг багийн засаг дарга нартай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн;</li> <li>- Байгууллагын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс нь 142.0 сая төгрөгийн хөрөнгийн тооллого хийгээгүй;</li> <li>-Өмнөх оноос үүссэн 1.6 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй;</li> <li>- Засаг даргын нөөц хөрөнгөөс 13.7 сая төгрөгийн өвс тэжээл худалдан авахдаа гэрээ байгуулаагүй, хөрөнгийг хүлээн авсан акт үйлдээгүй байна;</li> </ul>

Эх сурвалж: Төсвийн шууд захирагч нарын аудитын тайлан, аудитын гэрчилгээ

**Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар:**

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн өмчит 7 аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын харьяа 4 өрхийн эрүүл мэндийн төв болон орон нутгийн өмчит 4 аж ахуйн нэгж байгууллагад санал дүгнэлт өгч, 2 байгууллагыг түүвэрт хамруулж, 1 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Дүгнэлт өгсөн 7 байгууллагаас 6 байгууллагад “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт, “Цэвэр хот” ОНӨААТҮГ-т “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 1,898.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 391.7 сая төгрөгийн 6 алдааг санхүүгийн тайланд залруулж, 3.7 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож,

691.0 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах 21 албан шаардлага хүргүүлж, 811.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 3 зөвлөмж хүргүүлж ажиллав.

Хүснэгт 30. "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан орон нутгийн өмчит аж ахуйн нэгж

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
<b>"ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"</b>	
<b>ЦЭВЭР ХОТ ОНӨААТҮГ</b>	-Тайлант онд батлагдсан төсвөөс 102.3 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулж, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 49.2 сая, ХХОАТ-ын өглөг 20.2 сая, шатахууны өглөг 32.5 сая төгрөгийг шилжүүлээгүйгээс өр төлбөр үүссэн байна. - 2018 онд үүссэн НӨАТ-ын авлага 2.5 сая төгрөгийг барагдуулаагүй байна;

Эх сурвалж: Орон нутгийн өмчит аж ахуй нэгж байгууллагын аудитын тайлан, аудитын гэрчилгээ

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,401.1 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Үүнд:

- Тайлант хугацааны үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал нь тодруулгаас 541.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Мөн Богд сумын ЗДТГ-ын үнэ төлбөргүй хүлээн авсан 334.3 сая, Баянцагаан сумын ЗДТГ-ын үнэ төлбөргүй хүлээн авсан 973.6 сая, "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-ны 678.6 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн.
- Тайлант онд Галуут, Баян-Өндөр, Гурванбулаг, Жаргалант сумдын ЗДТГ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 25.1 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар авснаар бүртгэсэн, Өлзийт сумын ЗДТГ-ын бараа материалын дансанд бүртгэлтэй 79.2 сая төгрөгийн ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон өвс тэжээлийг, Өлзийт сумын ИТХ-ын үнэ төлбөргүй хүлээн авч, зарцуулсан шатахууныг Э-тайланд бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлснээр бүртгэсэн.
- "Баян өсөх агро" ОНӨААТҮГ-ийн 40.0 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийг урт хугацаат зээлийн ангиллаар бүртгэсэн.
- Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 25.9 сая төгрөгийн хандиваар ирсэн хөрөнгийг шилжүүлэн авснаар, 29.7 сая төгрөгийн дутагдсан моторыг хөрөнгөөс хасаж, авлагаар бүртгэсэн байхад акталсан ангиллаар, Баянцагаан сумын ЗДТГ-ын 198.7 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээг хийсэн байхад бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авснаар, "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын ОНХС-ийн эх үүсвэрээр бий болсон 15.0 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар авсан ангиллаар бүртгэсэн.

Аудитаар 4 зөрчил илэрсэнд зөрчлийг давтан гаргуулахгүй байх 4 зөвлөмжийг өгч байна.

### 5.1. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой.

**Илрүүлэлт:** Тайлант онд "Баян өсөх агро" ОНӨААТҮГ -ын дансаар 1.0 сая төгрөгийн орлого орж, 1.0 сая төгрөгийн зарлага гарч, бараа материалын дансанд 132.9 сая төгрөгийн хөдлөл өөрчлөлт орсон байхад Төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайланг гаргаж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дэх "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** "Баян өсөх агро" ОНӨААН-ын санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт дотоод аудитын албаар хяналт шалгалт хийлгэж эрсдэлтэй байгаа 132.9 сая төгрөгийн хөрөнгийг биетээр шалгах, Төсвийн тухай хуульд заасан цаглаварт

хугацаанд харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаа ирүүлж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой.

**Илрүүлэлт:** Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд э-тайлангийн тодруулга тайланд авлагын насжилт болон авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажсан эсэхийг үнэн зөв бүртгээгүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хангалттай хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3. дахь “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сангийн яамны Э-тайланд авлагын тодруулгад насжилтыг үнэн зөв бүртгэх, түүнд тавих хяналтыг сайжруулах.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

**Илрүүлэлт:** Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 124 мэдээллийг хугацаанд нь, 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа “Мэлтэс Оргих” ХХК, “Монгол болгар гео” ХХК, аймгийн Засаг дарга нарын хооронд 2023 онд байгуулсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-г шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8 “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны цахим хуудаст хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан Засаг даргатай байгуулсан 2 аж ахуйн нэгжийн гэрээг нөхөн байршуулж, мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр мэдээлж, хуулийг хэрэгжүүлэн ажиллах.

4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

**Илрүүлэлт:** Орон нутгаас жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих чиглэлээр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017.06.10-ны өдрийн 97 дугаар тогтоолоор “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийн санхүүжүүлэх” журам баталсан.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.01.31-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Баянхонгор аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн 2012-2016 онд олгосон зээлийн хөрөнгийг Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК-ийн харьяанд шилжүүлэн ЖДҮ-ийн дэмжих хөнгөлөлттэй зээлийг орон нутгийн өмчит ХХК-аар дамжуулан олгож байна.

Энэ нь ЖДҮ-г дэмжих тухай хуулийн 11.5 “Сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журмыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16.7-д заасны дагуу Засгийн газар батална”, Тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8.2.2 “Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно” гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аймгийн ИТХ-д жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжихэд олгож буй хөнгөлөлттэй зээлийг Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нийцүүлэх зөвлөмж хүргүүлэв.

Зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 09 дүгээр сарын 30-ны дотор, холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацааны үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал нь тодруулгаас 541.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Мөн Богд сумын ЗДТГ-ын үнэ төлбөргүй хүлээн авсан 334.3 сая, Баянцагаан сумын ЗДТГ-ын үнэ төлбөргүй хүлээн авсан 973.6 сая, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ны 678.6 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг бараа материал дансанд тус тус бүртгэсэн	1	1,986.5			1	1,986.5	1	1,986.5		
Тайлант онд Галуут, Баян-Өндөр, Гурванбулаг, Жаргалант сумдын ЗДТГ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 25.1 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар авснаар бүртгэсэн, Өлзийт сумын ЗДТГ-ын бараа материалын дансанд бүртгэлтэй 79.2 сая төгрөгийн ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон өвс тэжээлийг, Өлзийт сумын ИТХ-ын үнэ төлбөргүй хүлээн авч, зарцуулсан шатахууныг Э-тайланд бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлснээр бүртгэсэн байна.	1	105,2			1	105,2	1	105,2		
“Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ийн 40.0 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийг урт хугацаат зээлийн ангиллаар бүртгэсэн.	1	40.0			1	40.0	1	40.0		
Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 25.9 сая төгрөгийн хандиваар ирсэн хөрөнгийг шилжүүлэн авснаар, 29.7 сая төгрөгийн дутагдсан моторыг хөрөнгөөс хасаж, авлагаар бүртгэсэн байхад акталсан ангиллаар, Баянцагаан сумын ЗДТГ-ын 198.7 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээг хийсэн байхад бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авснаар, “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын ОНХС-ийн эх үүсвэрээр бий болсон 15.0 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар авсан ангиллаар тус тус бүртгэснийг аудитын явцад залруулав.	1	269.3			1	269.3	1	269.3		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>2,401.1</b>			<b>4</b>	<b>2,401.1</b>	<b>4</b>	<b>2,401.1</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд э тайлангийн тодруулга тайланд авлагын насжилт болон авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажсан эсэхийг үнэн зөв бүртгээгүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хангалттай хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	0					1	0
Тайлант онд "Баян өсөх агро" ОНӨААТҮГ -ын дансаар 1.0 сая төгрөгийн орлого орж, 1.0 сая төгрөгийн зарлага гарч, бараа материалын дансанд 132.9 сая төгрөгийн хөдлөл өөрчлөлт орсон байхад Төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайланг гаргаж ирүүлээгүй байна.	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>0</b>					<b>2</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 124 мэдээллийг хугацаанд нь, 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, мөн Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа "Мэлтэс Оргиж" ХХК, "Монгол болгар гео" ХХК, аймгийн Засаг дарга нарын хооронд 2023 онд байгуулсан "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"-г байршуулаагүй байна.	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>					<b>1</b>	<b>0</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 97 дугаар тогтоолоор "Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийн санхүүжүүлэх" журам баталсан нь ЖДҮ-г дэмжих тухай хуулийн 11.5 дах заалт, ЖДҮ-ийн дэмжих хөнгөлөлттэй зээлийг орон нутгийн өмчит ХХК-аар дамжуулан олгож байгаа нь Тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8.2.2 дахь заалтыг тус тус зөрчиж байна.	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>					<b>1</b>	<b>0</b>
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>0</b>					<b>2</b>	<b>0</b>

oOo